

# “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

## Нэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хандлага, мэргэжлийн түвшин

### Үйл явдлын өрнөл

Үйл явдлын хронологийн судалгаанаас үзэхэд монголын хэвлэл мэдээлэл 2008 оны 6 сарын 30-ны өглөөний 03 цагаас эхлэн сонгуулийн дүнтэй холбоотой мэдээлэл түгээж эхэлжээ. ХМХ-үүд МАХН, АН-ын сонгуулийн штабын мэдээ, санал тоололт будлиантсан тухай мэдээлж байв. 6 сарын 30-ны орой, 7 сарын 1-ний өдөр сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн иргэд Сүхбаатарын талбай дээр цуглаж буй, МАХН, АН-ын мэдэгдэл, хэвлэлийн бага хурал, Батзандан, Магнай нарын мэдэгдэл, Магнайн уриалж буй, Иргэний эвсэл, бусад жижиг гэгдэх намын мэдэгдэл, МАХН-ын байр руу дайрч буй, МАХН-ын байрыг шатааж буй, замын хөдөлгөөн хааж буй, иргэд, цагдаа нарын мөргөлдөөн, иргэд цагдаа нарыг зодож буй, цагдаа нар иргэд рүү буудаж буй, эд хөрөнгө эвдэж буй гэх мэт тухайн өдөр болсон үйл явдлыг шуурхай мэдээлсэн байна. Мөн жагсагчдад архи, мөнгө, бензин өгсөн, насанд хүрээгүй хүүхдүүд байгаа тухай мэдээлэл оржээ. Мөн жагсагчид яахаас ч буцахгүй улангассан, архичин, согтуу, траншейны хүмүүс, энэ бол зохион байгуулалттай хэрэг гэх мэт мэдээлэл цацагдаж байжээ.

Телевизийн 11 суваг 7 сарын 1-ний үйл явдал, түүний дараа үүсч бий болсон зөрчилт нөхцөл байдалтай холбоотой мэдээлэлд 709 цагийн эфирийнхээ 107 цаг буюу 15 хувийг зарцуулжээ. Гэхдээ суваг тус бүрээр авч үзвэл, энэ нь хоорондоо ялгаатай байна. Үүнээс МҮОНРТ (19%), Ийгл телевиз (18.7%) энэ мэдээлэлд хамгийн их цаг зориулсан ба дараа нь MN25 (12.1%), NTV (10.15%), С1(8.1%), TV5 (6.3%) суваг орж байна. TV9, UBS сувгийн цаг адилхан 4.9 хувьтай, харин ТМ суваг 3.7 хувь буюу хамгийн бага цагаа зориулжээ.

Өдөр тутмын сонинууд нийтлэлийн талбайнхаа 12.6 хувийг (118716 см<sup>2</sup>) 7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой мэдээлэлд зориулжээ. Хуваарилсан зай талбайн хувьд харьцангуй адил хэмжээтэй байгаа ба “Ардчилал”, “Зууны мэдээ” сонин тухайн үйл явдалтай холбоотой мэдээллийг бусдаасаа илүү нийтэлсэн байна.

Сэтгүүл зүйн төрөл хэлбэрийн хувьд авч үзвэл, ХМХ-үүд мэдээллийг шуурхай хүргэхийн тулд сурвалжлага түлхүү ашигласан ба ялангуяа телевизийн сувгууд шууд сурвалжлага түлхүү нэвтрүүлжээ

Мониторингийн баг олон улсад баримталдаг сэтгүүл зүйн түгээмэл стандартуудыг ХМХ-ийн мэргэжлийн түвшинд хийх шинжилгээнд суурь болгосон мөрдлөг болгож, мэдээллийн сэдэв агуулгын өргөн хүрээ, баримт, үзэл бодлыг заагласан эсэх, эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангасан эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийг ашигласан болно.

### Мэдээллийн сэдэв, агуулга

7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой мэдээллийн агуулга, сэдвийг тоймлон авч үзвэл, телевиз нөхцөл байдалтай холбогдуулан авсан арга хэмжээ - нөхцөл байдал - үр

# “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

дагавар гэсэн эрэмбээр, харин сонин нөхцөл байдлын шалтгаан - нөхцөл байдал - түүнтэй холбогдуулан авсан арга хэмжээ гэсэн эрэмбээр асуудалд ханджээ. Ерөнхийд нь дүгнэвэл, телевиз зөрчилт байдалтай холбоотойгоор авсан арга хэмжээнд, харин сонин зөрчилт байдлын учир шалтгаанд анхаарлаа хандуулжээ

- **Үйл явдлын шалтгаан**

Телевиз зөрчилт байдлын шалтгаанд нийт мэдээллийнхээ 19.6 хувь, сонин 30.5 хувийг зориулсан байна. Нийт мэдээлэлд МАХН, О.Магнай, Ж.Батзандан нар буруутай гэсэн мэдээлэл давамгайлж байна

Мониторингид хамрагдсан телевизийн сувгууд 7 сарын 1-ний өдрийн нэвтрүүлэгтээ тухайн хэрэг явдлын шалтгааныг, энэ бол нийгмийн суурь асуудал байсан, цагдаагийн талаар иргэд сөрөг хандлагатай байсан, сонгуулийн үр дүн нийгмийн хүлээлттэй зөрчилдсөн, МАХН сонгууль будлиантуулсан, АН-ын, мөн түүний дарга Ц.Элбэгдоржийн турхиралт байсан, О.Магнай, Ж.Батзандан нарын зохион байгуулсан үймээн, “Иргэний эвсэл”, БНН зохион байгуулсан, МАХН өөрөө зохион байгуулж, байраа шатаалгасан, цагдаагийн байгууллага шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, Сонгуулийн еөрөнхий хороо муу ажилласан, МАХН,АН хоёулаа буруутай, иргэд буруутай, Н. Энхбаяр буруутай, хятадууд турхирсан гэх мэтээр 16 янзаар тайлбарлажээ.

МҮОНТ дангаараа ажиллаж байсан онц байдлын үед үйл явдлын шалтгааны тайлбар 8 болон хоёр дахин буурч, эфирийн цагийн хамгийн их хувийг О.Магнай, Ж.Батзандан нарын зохион байгуулсан үймээн (22.6 хувь), “Иргэний эвсэл”, БНН зохион байгуулсан ( 18.4%) гэсэн мэдээлэл эзэлж байсан бол Магнай, Жаргалсайхан нар хяналтаа алдсан, алга болсон, дэврээсэн гэсэн агуулгатай мэдээлэл нь бусад шалтгаантай адил 11 хувийг эзэлжээ. Мөн МоАХ буруутай, сонгуулийн үр дүн нийгмийн хүлээлттэй зөрчилдсөн гэсэн мэдээлэл адилхан 7.1 хувь, Ийгл телевиз турхирч байна, Иргэний эвслийн зохион байгуулсан явдал гэх мэдээлэл 6 хувьтай байна.

Онц байдал цуцлагдсаны дараа тайлбарын тоо нэмэгдэж, 14 болон цагдаагийн талаар иргэд сөрөг хандлагатай байсан, АН-ын турхиралт, Н.Энхбаяр буруутай, хятадууд турхирсан зэрэг тайлбар хасагдаж, Засгийн газар харуцлагагүй ажилласан, Монгол Улсын баялгийн төлөөх тэмцэл, байдал хяналтаас гарсан гэх мэт тайлбар шинээр нэмэгджээ.

- **Үйл явдлын нөхцөл байдал**

Ийм мэдээлэлд телевиз 20.7 хувь, сонин 23.8 хувийг зарцуулжээ. Үүнд жижиг намууд, жагсаалд оролцогсдын сөрөг үйлдлийн талаарх мэдээлэл давамгайлсан байна

- **Үйл явдлын үр дагавар**

Үр дагаврын тухай мэдээлэлд телевиз 20.5 хувь, сонин 14.1 хувийг зориулжээ. Телевиз соёлын өв устсан, харин сонин хүний амь нас эрсэдсэн талаар илүү анхаарчээ

# “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

---

- **Үйл явдалтай холбогдуулан авсан арга хэмжээ**

Авсан арга хэмжээний тухай мэдээлэл телевизэд 24.6 хувь, сонинд 16.2 хувийг эзэлж байна. Аль аль нь дийлэнхдээ онц байдал зарласан тухай илүү анхаарчээ

- **Хүний эрхийн асуудал**

Телевиз 14.2 хувь, сонин 15 хувийг хүний эрхийн асуудалд зориулсан нь хамгийн бага байна.

## **Баримт, үзэл бодлыг заагласан байдал**

ХМХ-үүд олон нийтэд хүргэсэн мэдээллийнхээ дийлэнх (телевиз 67.4 хувь, сонин 76.2 хувь) хувьд баримтад түшиглэсэн байсан нь мэргэжлийн стандартыг хангасан дэвшилттэй үзүүлэлт байлаа.

## **Эх сурвалжийн тэнцвэр**

Мэргэжлийн сэтгүүл зүйд хоёр ба түүнээс дээш эх сурвалж ашиглаж, төлөөллийг адил тэнцүү хангавал мэргэжлийн хэм хэмжээг хангасан, мэдээлэл тэнцвэртэй болсон гэж үздэг.

- Мэдээллийн эх сурвалж дунджаар нэг, тухайлбал телевизэд 1.2, сонинд 1.5 байсан нь мэдээлэл өрөөсгөл байсныг харуулж байна. ХМХ тус бүрээр авч үзвэл, TV9 (2.1), С1 (1.8) суваг, “Өдрийн сонин (2.2)”, “Ардчилал (1.7)”, “Өнөөдөр (1.6)” сонины эх сурвалжийн тоо мэргэжлийн стандартад илүү дөхсөн байна.
- ХМХ-үүд албаны хүмүүсийн байр суурийг түлхүү дамжуулсан байна. Ингэснээр эх сурвалжийн төлөөллийн тэнцвэр алдагдаж, сонирхлын (хараат бус шинжээч, төрийн бус байгууллага гэх мэт), мөн үр дагавар хүртэгсэд (энгийн иргэд, хохирогчдын гэх мэт)-ийн дуу хоолойг орхигдуулан, нийгмийн олон талт, янз бүрийн үзэл бодлыг тусгах мэргэжлийн хэм хэмжээ алдагджээ. Телевизийн суваг тус бүрээр харьцуулбал, МҮОНТ-д албаны буюу төрийн байгууллагын эх сурвалж, MN25, UBS, TV5, TV9 сувагт улс төрийн нам, хүчин, NTV, SBN, TV8 сувагт мэргэжилтэн, шинжээч, С1, Ийгл, TV8 сувагт иргэдийн төлөөлөл давамгайлжээ